



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 35

Сайншанд сум

“Монгол малчин” аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол малчин” үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн төлөө хамтдаа” хөтөлбөрийн 1.25.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Монгол малчин” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулан, хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Т.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд бүтэц, байгаль орчин, хөдөөгийн бодлогын хорооны ахлагч /С.Одбаяр/, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Н.Хонгорзул/, нарт даалгасугай.

ДАРГА



С.ТҮМЭНБАЯР

443200122

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 19-ний
өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛ МАЛЧИН” АЙМГИЙН
ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг олон зуун жилийн туршид эрхэлж ирсэн малчид нь Монгол орны нүүдлийн соёл иргэншил, түүхийг бүтээгч, өв соёлыг тээгч, нийгэм, эдийн засгийн томоохон давхарга юм. Манай улсын нийт хүн амын 19.4 хувь нь буюу 617.3 мянган хүн малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 26.7 хувийг малчид бүрдүүлж, нийт өрхийн 25.8 хувийг малтай өрх, үүний 73.5 хувийг малчин өрх эзэлдэг бол Дорноговь аймгийн нийт хүн амын 19.5 хувь нь буюу 7024 хүн малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 21.3 хувийг малчид бүрдүүлж, нийт өрхийн 26.7 хувийг малтай өрх, үүний 79.1 хувийг малчин өрх эзэлж байна.

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 16-34 насны хүн ам 30.6 хувь, 35-59 насны хүн ам 53.7 хувь, 59+ дээш насны хүн ам 15.6 хувийг эзэлдэг. Нийт малчдын 57.9 хувь нь эрэгтэйчүүд байх ба 2197 буюу 31.3 хувь нь нийгмийн даатгалд, 5460 буюу 77.8 хувь эрүүл мэндийн даатгалд тус тус хамрагдсан.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, шаардлагатай уялдан мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, байгальд ээлтэй байх харилцаанд малчдын оролцоо, үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэх боллоо.

Монгол Улсын Их Хурлаас сүүлийн үед баталсан Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд малчдын зарим эрх, үүргийг нарийвчлан тодорхойлоод байна. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын баримт бичигт малчин өрх, малчдын талаар авч хэрэгжүүлэх тодорхой зорилтыг дэвшүүлжээ.

Тус аймаг нь бүхэлдээ говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон нутагтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг, салхины дундаж хурд 4,2-4,6 м/сек, гадаргын ус бараг үгүйгээс гүний усыг татаж ахуйн болон мал аж ахуйн үйлдвэрлэлд ашигладаг онцлогтой. Сүүлийн жилүүдэд цаг агаарын тааламжгүй нөлөөлөл болох хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зудын аюул цөөн бус удаа тохиолдож хуурайшилтын улмаас цөлжилтийн явц хурдасч байна.

Иймд хууль тогтоомж, төрийн урт, дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах, малчдын үйл ажиллагаа, амьжиргаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах, мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэхэд төрийн зүгээс малчдыг дэмжих, малчдын идэвх санаачилга, хувь нэмэр, оролцоог сайжруулах, чадавхжуулах, тэдгээрийн хөгжлийн тулгамдсан

зарим асуудлуудыг шийдвэрлэх шаардлага нь “Монгол малчин”дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулах замаар орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд дэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх;

2.2.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээнд малчдын оролцоог идэвхжүүлэх;

2.2.3. Малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх замаар орлого, ашгийг өсгөн орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрахад бодлогын дэмжлэг үзүүлэх;

2.2.4. Малчдын хамтын хоршил, эко санаачилга, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах;

2.3. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилтот бүлэг, хамрах хүрээ

3.1. Хөтөлбөрийн зорилтот бүлэг нь үндэсний өв соёлыг тээгч, уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч Дорноговь аймгийн иргэн-малчид байна.

3.2. Хөтөлбөрийн хамрах хүрээнд дор дурдсан малчид хамаарна:

3.2.1. Малын ашиг шимээр өрхийн үндсэн орлогоо бүрдүүлж, жилийн дөрвөн улирлын туршид өөрийн өмчийн малыг маллаж байгаа 16-аас дээш насны малчин;

3.2.2. Мал бүхий этгээдийн өмчлөлийн малыг гэрээний үндсэн дээр маллаж байгаа туслах малчин;

3.2.3. Суурин болон хагас суурин аж ахуйд мал бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр төрөлжсөн үүлдрийн малыг тэжээж, арчилж, маллаж байгаа малчин, саальчин;

3.2.4. Сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, баталгаажуулсан малчдын бүлэг, хоршоо.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4.1.1. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, малчдын мал маллах ухаан, аж ахуй эрхлэх арга барил, туршлагыг дэлгэрүүлсэн тэргүүний сумыг 2 жилд нэг удаа шалгаруулах;

4.1.2. Малчинд мэргэжлийн үнэмлэх, малчин өрхийн баталгааны тэмдэг олгох, хэрэглэхтэй холбогдсон хууль, журам, шаардлага, ач холбогдлыг таниулах;

4.1.3. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан малчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглахад сурган хүртээмжийг нэмэгдүүлж орон зайн хамаарлыг бууруулах;

4.1.4. Гэрээт болон туслах малчдад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;

4.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох, нэмүү өртгийн сүлжээнд малчдын оролцоог идэвхжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4.2.1. Сумдын мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэн бэлтгэх, нийлүүлэх малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлөлийг дэмжих;

4.2.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг малчин, мал бүхий өрх тус бүрээр тодорхойлох, чанарыг үнэлэх, бүртгэлжүүлэх, баталгаажуулах нэгдсэн системийг нэвтрүүлэх;

4.2.3. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, гарал үүслийг баталгаажуулан малчдын гар дээрээс хэрэглэгчдэд шууд хүргэх арга хэмжээ авах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4.3. Малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх замаар орлого, ашгийг нь өсгөн орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрахад бодлогын дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4.3.1. Малчин өрх, малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.2. Малчдыг эрүүл мэндийн үзлэг, оншлогоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

4.3.3. Малчин өрхийн гишүүдийг насан туршийн боловсролын төв, нэгжүүдээр дамжуулан боловсрол, мэдлэг, чадвар олгох, бага насны хүүхдүүдэд эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотойгоор сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх;

4.3.4. Улс, аймгийн аварга малчдыг тодорхойлох, шалгаруулахад орон нутгийн орлого багатай өрхүүдийг малжуулах, ядуурлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэсэн бодит нотолгоо олгох зохицуулалтыг бий болгох;

4.4. Малчдын хамтын хоршил, эко санаачилга, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4.4.1. Бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх;

4.4.2. Малын тоог бэлчээрийн даацад тохируулан өсгөх;

4.4.3. Бэлчээр дэх худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлэх;

4.4.4. Бэлчээрт хор хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, шавжтай тэмцэхэд малчид, мал бүхий иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

Тав. Хөтөлбөрийн үр дүн

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

5.1.1. Малчдын мэдлэг, чадавх сайжирснаар мал аж ахуй эрхлэх шинэ мэдлэг, техник, технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэвшил гарна.

5.1.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналт сайжирч, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэнийн сүлжээнд өрсөлдөх чадварын өөрчлөлт, дэвшил гарна.

5.1.3. Малчин өрхийн нөөц ашиглалт, бүтээмжийн түвшин өсч, мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, малчдын орлого, ашиг нэмэгдэнэ.

5.1.4. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бататган сайжруулах үйл ажиллагаа эрчимжиж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, хөгжүүлэх эрх зүй, хөрөнгө оруулалтад зэрэг нөлөөлөл авчирна.

5.1.5. Хөдөөгийн хөгжилд малчдын оруулах санаачилга, хувь нэмэр голлох үүрэг гүйцэтгэж, малчдын орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгаа сайжирна.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2019/	Зорилтот түвшин /2024/
1.	Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх	Туршлага судлах арга хэмжээ	тоо	1	4
		Туршлага судлах арга хэмжээнд хамруулсан малчин	тоо	18	104
		Мэдээллийн сантай болсон малчин өрх	тоо	-	4231
		Малчдад зориулсан 2-5 хоногийн танхимын сургалт /сум бүрт жилд 1 удаа/	тоо	-	56
		Сумдад зохион байгуулсан 2-5 хоногийн танхимын сургалтад хамрагдсан малчин /Нэг удаа-10 хүн/	тоо	-	560
		Малчдын нэгдсэн судалгаа, мэдээллийн программ нэвтрүүлсэн сум	тоо	-	14
		Хөдөө аж ахуйн чиглэлээр тэргүүн туршлага судлан нэвтрүүлсэн шилдэг сум	тоо	-	2
		“Масс мессеж” үйлчилгээнд хамрагдсан малчин	хувь	84	100
2.	Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн	Хөдөө аж ахуйн сургагч багштай сум	тоо	-	14
		Малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлөл	тоо	-	14

	тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох зорилтын хүрээнд дараахь ажиллагааг хэрэгжүүлнэ.	Гарал үүслийн гэрчилгээг системээс олгодог сум	тоо	-	14	
			Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ, чанарын талаар тусгайлан бэлтгэсэн нэвтрүүлэг	тоо	-	12
			Малчдын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	тоо	-	4
			Малчдын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчилах нэгдсэн цэг	тоо	-	1
3	Малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг замаар орлого, ашгийг өсгөн орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрахад бодлогын дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн үзлэг, оншилгоо, шинжилгээ, эмчилгээнд малчдын хамрагдалт	хувь	15	50	
		Эрүүл мэндийн мобайл технологи нэвтрүүлсэн сум	тоо	4	14	
		Малжуулсан өрх	тоо	25	150	
4.	Малчдын хамтын хоршил, эко санаачилга, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах	Бэлчээр ашиглалтын журамтай сум	тоо	3	14	
		Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй сум	тоо	-	14	
		Ус, бэлчээр ашиглалтын холбоотой сум	тоо	5	14	
		Шинээр болон сэргээн засварласан инженерийн хийцтэй худаг	тоо	48	70	
		Шинээр болон сэргээн засварласан гар худаг	тоо	50	200	
		Бэлчээрт хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, шавжтай тэмцсэн сум	тоо	5	8	

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.1.2. Олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж;

7.1.3. Арилжааны банкны эх үүсвэр;

7.1.4. Малчид, мал бүхий этгээдийн хөрөнгө оруулалт;

7.1.5. Гадаад, дотоодын байгууллагын хөрөнгө оруулалт;

7.1.6. Бусад эх үүсвэр.

**Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх
хяналт-шинжилгээ, үнэлгээ**

8.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэс нь хөтөлбөрийн жил бүрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

8.2. Хөтөлбөрийн 8.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

-----o0o-----